



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014-ын 06 сарын 26-и  
адар

Луузи: 102

Улаанбаатар хот

Журам шинчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.3, 20.1.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 01/1824 дугаартай албан бичгээр өргөн мэдуулсан саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөний нягтрал, ачааллыг бууруулж, хөдөлгөөний зрчмийг нэмзгүүлэх зорилгоор "Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам"-ыг хавсралтаар шинчлэн баталсугай.
2. Журмыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж, хэрэгжүүлэн ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 37 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Д.БАТТУЛГА

ЗОХ, АЧИАХ.  
Ачилгээж  
төслийн  
хөтөл хөгжүүлэх  
Дэлгээ  
20.06.2014  
110100281

Нийслэлийн иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 15-ний  
өдрийн 102 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ГУДАМЖ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД АЧААНЫ АВТОМАШИНЫГ  
ЦАГИЙН ХЯЗГААРЛАЛТАЙГААР ОРОЛЦУУЛАХ  
ТҮР ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэр дэх ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах, нийслэлийн авто зам, замын байгууламжийг эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, стандартын шаардлага хангаагүй бүх жингийн зөвшөөрөгдхөх хэмжээнээс хэтэрсэн автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, тээвэрлэлтэнд хяналт тавих үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах, нийслэлийн гудамж замд хөдөлгөөний ачааллыг тэнцвэржүүлэх, хөдөлгөөнд өрөлцөгчдүүн ая тухтай, аюулгүй зорчих нехшийг дээшлүүлэх үүднээс ачааны автомашины хөдөлгөөнд тодорхой хязгаарлалт тогтооход оршино.

1.2. Энэхүү журам нь нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

Хоёр. Ачааны автомашины хөдөлгөөнд тавих хязгаарлалт,  
түүний төрөл, зохицуулалт

2.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлт эрхэлж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг гудамж, замуудын хүрээ болон тухайн тээврийн хэрэгслийн төрөл, ангиллаас хамаарч дараах байдлаар зохион байгуулна.

2.2. Бүх жин нь 3500 кг болон түүнээс бага жинтэй ачааны автомашиныг "B", бүх жин нь 3500 кг-аас дээш жинтэй ачааны автомашин болон тусгай зориулалтын тээврийн хэрэгслийдийг "C", чиргуултэй автомашиныг "CE" гэсэн ангиллаар зөвшөөрөл олгоно.

2.3. Хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон цаг, гудамж замуудын нэр, байршил:

2.3.1. "B" ангиллын ачааны автомашин өдрийн 11.00 цагаас 20.00 цагийн хооронд дараах замуудаар явахыг хориглоно.

- Бага тойруугаас дотогш замуудад
- Энхтайваны өргөн чөлөөнд Монгол Улсын Боловсролын Их сургуулийн уулзвараас Цэцэг төвийн уулзвар хүртэл
- Чингисийн өргөн чөлөөнд Төв шуудангийн зүүн урд уулзвараас Энхтайваны гүүрний урд уулзвар хүртэл

2.3.2. "C", "CE" ангиллын ачааны автомашиныг зорчихыг хориглосон гудамж, замууд:

- Бага тойруугийн гудамж, түүнээс дотогш замуудад
- Энхтайваны өргөн чөлөөнд /Зүүн 4 замын уулзвараас Баруун 4 замын уулзвар хүртэл/
- Чингисийн өргөн чөлөөнд /Төв шуудангийн зүүн урд уулзвараас 120 мянгатын уулзвар хүртэл/
- Энэбишийн өргөн чөлөөнд /Өргөэ кино театрийн уулзвараас Тасганы овооны уулзвар хүртэл/

- Сеүлийн гудамжинд
- Усны гудамжинд /Урбанек худалдааны төвийн уулзвараас Циркийн хойд уулзвар хүртэл/

2.3.3. "С" ангиллын ачааны автомашин өдрийн 08.00 цагаас 21.00 цагийн хооронд зорчихыг хориглосон гудамж замууд:

- Энхтайваны өргөн чөлөөнд /5 шарын уулзвараас Москвагийн гудамжаар, Баруун 4 зам хүртэл/
- Өнөр хорооллын гудамжинд
- Их тойруугаас дотогш замуудад
- Нарны зам /Нарантуул Олон улсын худалдааны төвийн баруун урд уулзвараас Материал импексийн хойд уулзвар хүртэл/
- Олимпийн гудамжинд
- Ард Аюушийн өргөн чөлөөнд /3, 4 дүгээр хорооллын эцсээс Өргөө кинотеатрын уулзвар хүртэлх замд/
- Жалханз хутагт Дамдинбазарын гудамжинд
- Энгельсийн гудамжинд /МеханикИнженерийн Сургуулийн уулзвараас хуучин үйлдвэрийн цагаан хаалганы уулзвар хүртэл/
- Чингисийн өргөн чөлөөнд /120 мянгатын уулзвараас Дулааны цахилгаан станцын уулзвар хүртэл/
- Нийслэлийн өргөн чөлөөнд /120 мянгатын уулзвараас Их монгол улсын гудамжны уулзвар хүртэл/
- Зайсангийн гудамжинд /120 мянгатын уулзвараас Хөдөө аж ахуйн Их сургуулийн уулзвар хүртэл/
- Их Монгол улсын гудамжинд /Замын Цагдаагийн газрын уулзвараас Гандийн гудамжны уулзвар хүртэл/

2.3.4. "СЕ" ангиллын ачааны автомашин өдрийн 08.00 цагаас 21.00 цагийн хооронд зорчихыг хориглосон гудамж замууд:

- "С" ангиллын ачааны автомашины хөдөлгөөнийг хориглосон бүх гудамж замууд
- Гандийн гудамжинд
- Дунд голын гудамж /Механик Инженерийн Сургуулийн уулзвараас Энхтайваны гүүрний зүүн доод уулзвар хүртэл/
- Энхтайваны өргөн чөлөөнд /Зүүн 4 замын уулзвараас Офицеруудын ордны уулзвар хүртэл/
- Намьянжугийн гудамж
- Их тойрууд /Сансарын аюулгүйн тойроос Зүүн 4 зам хүртэл/
- Хувьсгалчдын гудамжинд /Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн зүүн урд уулзвараас Гэсэр сүмийн урд уулзвар хүртэл/

2.4. Хязгаарлалт тогтоосон дээрх гудамж, замуудаас бусад замаар ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл нь нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх эрх бүхий "ЕС зөвшөөрөл" авч замын хөдөлгөөнд оролцно.

2.5. "Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл" авах тээврийн хэрэгсэл нь энэхүү журмын 2.4.-д заасан "ЕС зөвшөөрөл"-ийг авсан байна.

2.6. Доор дурьдсан тээврийн хэрэгсэлд ажил, үйлчилгээ явуулах нехцэл шаардлагыг нотопсон баримт бичгийг үндэслэн 2.4.-т заасан "ЕС зөвшөөрөл"-ийг олгох ба энэхүү журмын 2.3-т заагдсан хязгаарлагдсан гудамж, замуудын хөдөлгөөнд замын болон дагалдах хуудасанд заагдсан цаг маршуургаар нэвтрэх хөдөлгөөнд оролцно. Үүнд:

- Ус сувгийн удирдах газрын харьяа ариутгах татуургын болон цэвэр усны шугам хоолойн засвар, дуудлагын автомашин

- Дулааны шугам сүлжээний засвар, дуудлагын автомашин
- Цахилгаан шугамын гэмтлийн автомашин, троллейбусны шугамын засварын автомашин
- Холбооны шугамын гэмтлийн автомашин
- Гэрзлтуулгийн засвар, дуудлагын автомашин
- Гадна реклам чимэглэл, мэдээллийн байгууламжийн засварын автомашин
- Техникийн тургэн тусламжийн автомашин
- Нийслэлийн зам, засвар, арчлалт, хамгаалалтын автомашин
- Нийслэлийн тохижилт үйлчилгээний автомашин
- Шуудан зееврийн автомашин
- Хэвлэл мэдээллийн байгууллагын тусгайлан тоноглосон автомашин
- Хүнсний тургэн муудах бүтээгдэхүүн тээвэрлэдэг хөргүүр бүхий тусгай тоноглосон автомашин

**Гурав. Ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа  
эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг үүрэг**

3.1. Ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь дараах үүрэгтэй.

3.1.1. "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2011 стандартад Заагдсан бүх жингийн зөвшөөрөгдхөх хэмжээг мөрдөх;

3.1.2. Аюултай ачаа, овор ихтэй, урт, хүнд ачаа тээвэрлэх бол Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 22-ийн 4, 5, 6, 7 дахь заалтуудыг мөрдхөөс гадна "Аюултай ачаа. Ангилал, техникийн ерөнхий шаардлага" MNS4978:2000, "Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага" MNS 5345:2011 стандартуудыг мөрдөх ба Замын цагдаагийн газар, Нийслэлийн Авто замын газраас тодорхойлолт авч тээвэрлэлтийг гүйцэтгэх;

3.1.3. Хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгддэх байгаа тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах үндсэн шаардлагуудыг хангахаас гадна зам талбай бохирдуулахгүй байх /ачиж явaa ачаа нь унахгүй, асгарахгүй, гоожихгүй, хийсэхгүй байх/ нөхцлийг хангаж Монгол Улс. Замын хөдөлгөөний дүрмийн 3 дугаар хавсралтын дагуу үүрэг хүлээнэ.

3.1.4 Тээвэрлэгч байгууллагууд нь түгээмэл тархацтай ашигт малти элэгт нийслэл хот уруу орох зангилаа газарт терминал байгуулан тээврийн хэрэгслийн бүх жингийн зөвшөөрөгдхөх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

3.1.5 Барилгын бетон зуурмаг үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж байгууллага нь тээврийн хэрэгслийн бүх жинг хэмжих суурин авто пууг ажиллуулна.

### **Дөрөв. Бүрдүүлэх баримт бичиг**

4.1. Энэхүү журмын 2.2.-д заасан түр зөвшөөрлийг авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

4.1.1. Түр зөвшөөрөл авах хүсэлт гаргасан албан бичиг

4.1.2. Хязгаарлалт тогтоосон гудамж, замууд руу зайлшгүй тохиолдлоор зорчих шаардлагыг нотолсон баримт, хотын бүтээн байгуулалт, барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэл бол тухайн барилгын ажил эхлэх зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ачааг тээвэрлэж буйг нотолсон баримт бичиг;

4.1.3 Аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээний хуулбар

4.1.4 Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар

4.1.5. Тээврийн хэрэгслийн ерөнхий байдлын фото зураг /4 талаас авсан/  
4.1.6. Энэхүү журмын 2.4-т заасан зөвшөөрөл

4.2. Энэхүү журмын 2.4-т заасан "ЕС зөвшөөрөл"-ийг авах тээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт орж гэрчилгээ авсан, татвар, хураамжийг бүрэн телж, холбогдох даатгалд хамрагдсан байх;

4.3. Энэхүү журмын 4.1, 4.2-т заасан баримт бичгийг бүрдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Нийслэлийн Тээврийн газраас ажлын 1-3 хоногт зөвшөөрлийг олгоно.

4.4. Энэхүү журмын 2.2-т заасан түр зөвшөөрлийг хязгаарласан гудамж, замууд руу зайлшгүй шаардлагаар зорчих өдрийн тоогоор олгох бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын 2013 оны "Хураамжийн хэмжээ тогтоо тухай" 8/34 дүгээр тогтоолын 1 дүгээр заалт, 2.4-т заасан "ЕС зөвшөөрөл"-ийг олгоходоо 6 сарын хугацаагаар олгох бөгөөд 8/34 дүгээр тогтоолын 2 дугаарт заасныг мөрднө.

#### Тав. Журмыг хэрэгжүүлэх байгууллагуудын үүрэг

5.1. Эрх бүхий байгууллагууд нь Автотээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгон дараах үүргийг хүлээн ажиллана.

5.1.1. Ачааны автомашины хөдөлгөөнд цагийн хязгаарлалт тогтоосон гудамж замуудад өдрийн цагаар /08.00-21.00/ хөдөлгөөн дунд зам засварын ажил хийхийг хориглоно.

5.1.2. Журмын хэрэгжилтийг хангах ажлыг Нийслэлийн Тээврийн Газар зохион байгуулах бөгөөд Нийслэлийн Замын Цагдаагийн газар, Нийслэлийн Авто Замын газартай хамтран жилд 2 удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж тайланг нийслэлийн Засаг даргад танилцуулна.

5.2. Нийслэлийн Тээврийн газар дараах үүрэг хүлээж ажиллана.

5.2.1 Ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох;

5.2.2 Ачаа тээвэрлэлт эрхлэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахдаа иргэдэд хүндрэл, чирэгдэл учруулахгүй байх үүднээс цахим мэдээллийн сүлжээг ашиглах бодлого баримтлах;

5.2.3. Ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааны бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх;

5.2.4 Холбогдох байгууллага, иргэдийг нийслэлийн нутаг дэвсгэр дэх ачаа тээвэрлэлттэй холбоотой мэдээ, мэдээлээр хангах;

5.2.5. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ачаа тээвэрлэлтийг зохицуулах, хяналт тавих эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах чиглэлээр хамтарч ажиллах;

5.3. Нийслэлийн Замын цагдаагийн газар дараах үүрэгтэй ажиллана.

5.3.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэлд хяналт тавьж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

5.3.2. "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2011, "Аюултай ачаа, Ангилал, техникийн ерөнхий шаардлага" MNS4978:2000, "Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага" MNS 5345:2011 стандартууд болон холбогдох бусад эрх зүйн баримтуудад заагдсан шаардлагыг ҳангагүй автотээврийн хэрэгслийг нийслэлийн нутаг дэвсгэр дэх замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээг авах;

5.3.3. Ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл нь авто зам, замын байгууламжийг бохирдуулахгүй байх нөхцлийг хангасан эсэхийг шалган, зөрчлийг арилгуулах;

5.3.4. Энэхүү журмыг зөрчиж тээвэрлэлт гүйцэтгэсэн тохиолдолд түр зөвшөөрөл, эрхийг хураан авч Нийслэлийн Тээврийн газарт шилжүүлэн хамтран шийдвэрлэх;

#### 5.4. Нийслэлийн Авто Замын газар дараах үүрэгтэй ажиллана.

5.4.1. Нийслэлийн нутаг дэвсгэрийн авто зам, замын байгууламжийг арчлах, хамгаалах, авто замын даац, ашиглалттай холбоотой мэдээллээр холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хангах;

5.4.2. Авто замын тухай хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах;

#### Зургаа. Бусад зүйл, хүлээх хариуцлага

6.1. "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2011 стандартыг зөрчин тээвэрлэлт хийсэн тохиолдолд "ЕС зөвшөөрөл" болон "Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл"-ийг хураан авч, замын хөдөлгөөнд оролцуулахгүй.

6.2. Дээрх зөрчлийг давтан гаргасан тохиолдолд "ЕС зөвшөөрөл" болон "Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл"-ийг тухайн хагас жилийн хугацаанд дахин олгохгүй.

6.3. Барилгын бетон зуурмаг тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2011 стандартыг зөрчин хэтрүүлэн тээвэрлэлт хийсэн тохиолдолд "ЕС зөвшөөрөл" болон "Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл"-ийг хураан авч, замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээ авна.

6.4. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын Автотээврийн тухай хууль, Автозамын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны хариушлагын тухай хууль болон энэхүү журамд заасан бусад хариуцлага хүлээлгэнз.